



Орхон аймгийн Нийгмийн даатгалын
хэлтсийн даргын 2022 оны 11 дүгээр
сарын 20-ны өдрийн а/23 дугаар
тушаалын II хавсралт



**ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ГАРЫН АВЛАГА**

Баримт бичгийн дугаар: ЧГА-2022

Баталсан: НДХ-ийн дарга Б.АНАР
Хянасан: ХШДАТ тасгийн дарга Н.БАТ-ЭРДЭНЭ
Боловсруулсан: Авлигын эсрэг менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх
ажлын хэсэг

Эх хувь	Дардас
<u>Хяналттай хувь</u>	
Хуулбар хувь	
Хүчингүй хувь	
Хяналтгүй хувь	



ӨМНӨХ ҮГ

Нийгмийн даатгалын байгууллагын менежментийн чадавхийг бэхжүүлэх, иргэдийг эрсдлээс хамгаалах, удирдлага, хяналтын тогтолцоог үр ашигтай, оновчтой зохион байгуулах, төрийн байгууллагад авлига бий болох шалтгаан нөхцөлийг арилгах, хууль эрх зүйн орчныг сайжруулах, төрийн албан хаагчийн ёс зүйг дээшлүүлэх, хариуцлагыг чангатгах, шударга ёсыг бэхжүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, хүнд суртал, чирэгдлийг арилгах, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор олон улсын ISO 37001:2016 стандартад нийцсэн менежментийн тогтолцоог нэвтрүүлэх ажлыг манай байгууллага 2022 оноос эхлэн үе шаттайгаар, холбогдох стандартаар тогтоосон шаардлагын дагуу нэвтрүүлж эхэлсэн юм.

Авлигын эрсдлийг бууруулах, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан нөхцөлийг арилгах, эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хэлтсийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангаж, албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага дээшлүүлэх, даатгуулагчдын сэтгэл ханамжийн түвшинг нэмэгдүүлэхээр зорилт тавин ажиллалаа.

Бид байгууллагынхаа эрхэм зорилго, хэтийн зорилго, эрхэмлэх үнэ цэнэ, чанарын бодлого, чанарын зорилтыг тодорхойлж, шилдэг мэргэшсэн, үнэнч ёс зүйтэй, хамтын ажиллагааг дэмжигч, эелдэг тусч, эрч хүчтэй, бүтээлч санаачилгатай хамт олон байхаа илэрхийлж баримтжуулав.

Манай байгууллагаас үйл ажиллагаандаа Авлигын эсрэг стандарт ISO 37001:2016 стандартад нэвтрүүлэх стратегийн ач холбогдол бүхий шийдвэрийг 2022 онд албан ёсоор зарлан олон нийтэд тунхагласнаар нийгмийн даатгалын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, чанартай үйлчилгээг даатгуулагчдад хүргэн тэдний сэтгэл ханамжийг дээшлүүлэхийн төлөөх тасралтгүй сайжруулалтын ухамсарт хандлага нийгмийн даатгалын ажилтнуудын харилцааны болон үйлчилгээний соёл, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх талаар хүчин чармайлт гаргахаа нотолсон билээ.



Өнгөрсөн хугацаанд бид Авлигатай тэмцэх менежментийн тогтолцоог нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд Бүтээмж, стандарт процесс хөгжүүлэлтийн зөвлөл байгуулан, тусгай удирдамж батлан төлөвлөгөөний дагуу ажиллаж ажлын байрны зураг авалт хийн, ажилтнууддаа стандартын зорилго, ач холбогдол, шаардлагуудын талаарх мэдлэг ойлголтыг олгох сургалтуудыг зохион байгуулж, Авлигын эсрэг стандарт нэвтрүүлсэн төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагын туршлагаас суралцсан.

Авлигатай тэмцэх менежментийн тогтолцооны үндсэн суурь нь болох байгууллагын үйл ажиллагааны процессыг тодорхойлон томъёолох ажлыг Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн бүтцийн нэгж, байцаагч, албан хаагч бүрийн ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан чиг үүрэг бүрээр зохион байгуулснаар нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны үндсэн болон туслах процессуудыг тодруулан, урсгалын диаграммаар баримтжуулж, тэдгээрийн орц, гарцуудын шаардлагуудыг шинжлэн тодорхойллоо.

Олон улсын энэхүү стандартад **Төлөвлө-Гүйцэтгэ-Шалга-Сайжруул /ТГШС/** мөчлөг болон эрсдэлд суурилсан сэтгэлгээг хослуулсан үйл явцын аргыг хэрэглэсэн. Үйл явцын энэ арга нь байгууллагын үйл явц ба тэдгээрийн харилцан үйлчлэлийг төлөвлөх боломжийг бүрдүүлнэ.

ТГШС мөчлөг нь байгууллагын үйл явцыг хангалттай нөөц, зохих удирдлагаар хангах, мөн сайжруулах боломжийг тодорхойлж, хэрэгжүүлэх бололцоог олгоно. Эрсдэлд суурилсан сэтгэлгээ нь байгууллагын үйл явц, авлигын чанарын менежментийн тогтолцоог төлөвлөсөн үр дүнгээс хазайхад нөлөөлсөн хүчин зүйлийг тодорхойлох, сөрөг үр дагаврыг бууруулах, бий болсон боломжийг бүрэн ашиглах нөхцөлийг бүрдүүлэх, сэргийлэх, хяналтыг хэрэгжүүлэх бололцоог олгоно.

Хувьсан өөрчлөгдөж байгаа нийгмийн шаардлагыг тогтвортой хангах, авлигын эсрэг үйл ажиллагаагаа ирээдүйн хэрэгцээ ба найдлагад чиглүүлэх, иргэд олон нийтийг авлигад өртөх эрсдлээс хамгаалах асуудал нь байгууллагын өмнө сорилтыг бий болгож байна.

Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс Авлигын эсрэг олон улсын *ISO 37001:2016* стандартыг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд байцаагч, ажилтан бүрийн санаачилга, бүтээлч хандлага, оролцоо, хүчин чармайлт эрхэм чухал



болохыг онцлон, хамт олны нэгдмэл зорилгын төлөө хөгжиж дэвжихийг Та бүхэндээ уриалж байна.

ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.АНАР



НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1 Нийгмийн даатгалын байгууллага

Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс 1976 оны 05 дугаар сард үйл ажиллагаагаа эхэлж, 07 дугаар сарын 01-ний өдрөөс тэтгэвэр олгож, 10 дугаар сард “Хөдөлмөр нийгэм хангамжийн хэлтэс” нэртэйгээр дарга, хөдөлмөр ба тэтгэврийн байцаагч гэсэн 3 орон тоотойгоор байгуулагдсан байна.

Одоогийн байдлаар:

- Санхүү бүртгэлийн тасаг
- Үйлчилгээний тасаг
- Хамралт, орлого, шимтгэлийн тасаг
- Хяналт шалгалт, дотоод аудитын гэсэн 4 тасагтай 40 орон тоотойгоор Орхон аймгийн хэмжээнд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлж байна. Мөн сүүлийн жилүүдэд нийгмийн даатгалын зарлага жил бүр өсч орлогоосоо давах хандлагатай байгаад дүгнэлт хийж, орон нутгийн өөрөө удирдах байгууллагатай хамтран ажилласны үр дүнд нийгмийн даатгалын хамрах хүрээг нэмэгдүүлэх зорилготой 10 төлөөлөгчийг журмын дагуу ажиллуулж байна.

Эрхэм зорилго

Бид Даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ.

Хэтийн зорилго

Манай байгууллага 2030 он гэхэд бүх нийтийн насан туршийн нийгмийн баталгааг хангахуйц чадамжтай, нийгмийн даатгалын цогц үйлчилгээ бүхий Даатгагч болно.

Үнэ цэнэ: ШҮХЭР

Ш- ШИЛДЭГ, МЭРГЭШСЭН

Ү- ҮНЭНЧ, ЁС ЗҮЙТЭЙ

Х- ХАМТРАН АЖИЛЛАХ ЧАДВАРТАЙ

Э- ЭЕЛДЭГ, ТУСЧ

Р- ЭРЧ ХҮЧТЭЙ. БҮТЭЭЛЧ САНААЧИЛГАТАЙ



1.2 Авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцооны хамрах хүрээг тодорхойлох

Авлига ашиг сонирхлын зөрчил гарахаас урьдчилан сэргийлэн хэрэгжүүлэх бүхий л үйл ажиллагаа, үйл явцад дараах сүбъектүүд хамаарна. Үүнд:

- Нийгмийн даатгалын ажилтан, албан хаагчид, нийгмийн даатгалын хэлтэст ажилд орох хүсэлтэй ажил горилогч иргэд
- Нийгмийн даатгалын үйлчилгээ авч буй иргэд, даатгуулагч, аж ахуйн нэгж, байгууллагууд
- Нийгмийн даатгалын байгууллагатай хамтран ажиллах гэрээ бүхий иргэн, аж ахуйн нэгж байгууллага
- Дээд шатны байгууллага, салбарын ижил түвшний байгууллага, тэдгээрийн албан хаагчид, удирдлага, хууль, хяналтын байгууллагууд
- Тусгай зөвшөөрөл, гэрчилгээ олгох эрх бүхий хөндлөнгийн хяналтын байгууллага, тэдгээрийн албан хаагчид
- Нийгмийн даатгалын байгууллагатай шууд болон шууд бусаар харилцах иргэн, аж ахуйн нэгж, байгууллага

Энэхүү гарын авлага нь нийгмийн даатгалын байгууллагын авлига ашиг сонирхлын зөрчил үүсэх шалтгаан нөхцөл түүнийг тодруулах, урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоонд холбогдох чанарын хяналт, стандарт үйл ажиллагааны журам, ажлын заавар, бүртгэлийн маягтуудыг хамруулсан нийгмийн даатгалын бүхий л үйл ажиллагаа хамарна.

ХОЁР. НОРМАТИВ ИШ ТАТАЛТ

Энэхүү гарын авлагад иш татсан норматив баримт бичиг нь түүний үндэслэл болох заалтуудыг агуулна. Иш татсан норматив баримт бичгийн хамгийн сүүлчийн хэвлэлийг хэрэглэнэ.

ГУРАВ. НЭР ТОМЪЁО БА ТОДОРХОЙЛОЛТ, ТОВЧЛОЛ

Нэр томъёо	Тайлбар
Чанар	Хувийн багц үзүүлэлт нь шаардлага биелүүлэх хэр хэмжээ
Шаардлага	Гол төлөв мэдээжийн буюу албан журмын шинжтэй, тогтоосон хэрэгцээ буюу хүсэл
Чанарын гарын авлага	Байгууллагын ЧУТ-г тогтоож буй баримт бичиг
Удирдлага	Байгууллагыг удирдан чиглүүлэх, хянах зохицуулсан үйл ажиллагаа
Хэрэглэгчийн сэтгэл ханамж	Хэрэглэгчийн шаардлага ямар хэмжээнд биелсэнийг хэрэглэгчээс мэдрэх байдал



Чадвар	Уг бүтээгдэхүүнд тавих шаардлагыг хангаж чадахуйц бүтээгдэхүүнийг хийх байгууллагын тогтолцоо буюу үйл явцын чадвар
Удирдлагын тогтолцоо	Бодлого, зорилтуудыг тогтоож тэдгээр зорилтуудад хүрэх тогтолцоо
Чанарын удирдлагын тогтолцоо	Байгууллагыг чанарын талаар удирдан чиглүүлэх, хянах удирдлагын тогтолцоо
Чанарын бодлого	Дээд удирдлагаас албан ёсоор илэрхийлсэн чанарт хамаарах, байгууллагын нийт зорилго ба чиглэл
Чанарын зорилт	Чанарын талаар хийхээр буюу хүрэхээр зорьж эрмэлзсэн зүйл
Чанарын удирдлага	Байгууллагын чанарын талаар удирдан чиглүүлэх, хянах зохицуулагдсан үйл ажиллагаа
Чанарын төлөвлөлт	Чанарын зорилтыг тогтоох, ажлын шаардагдах үйл явц чанарын зорилтыг биелүүлэхтэй холбоотой нөөцийг тодорхойлоход чиглэсэн, чанарын удирдлагын нэг хэсэг
Чанар хангалт	Чанарын шаардлага биелэгдэнэ гэсэн итгэл бий болгоход чиглэсэн, чанарын удирдлагын нэг хэсэг
Чанар сайжруулалт	Чанарын шаардлагыг биелүүлэх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн, чанарын удирдлагын нэг хэсэг
Үр нөлөө	Төлөвлөсөн үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд хүрсэн байдлын хэмжээ
Хэрэглэгч	Бүтээгдэхүүн, үйлчилгээг хүлээн авдаг байгууллага эсвэл хувь хүн
Үйл явц	Оролтыг гаралт болгон хувиргах харилцан уялдаа буюу харилцан үйлчлэл бүхий багц үйл ажиллагаа
Бүтээгдэхүүн	Үйл явцын үр дүн
Журам	Үйл ажиллагаа буюу үйл явцыг гүйцэтгэх тогтоосон арга зам
Ажлын заавар	Байгууллагын тодорхой чиглэлийн үйл ажиллагааны арга хэлбэр, зохион байгуулалт, дэс дарааллыг нарийвчлан заасан баримт бичиг
Үл тохирол	Шаардлага үл биелж байгаа байдал
Залруулах үйл ажиллагаа	Нэгэнт илэрсэн үл тохирол буюу үл хүсүүштэй бусад байдлын шалтгааныг арилгахын тулд явуулах ажиллагаа
Бүртгэл	Хүрсэн үр дүнг тогтоож буй буюу гүйцэтгэсэн үйл ажиллагааны бодит баримт болж буй баримт бичиг

**Товчилсон үг:**

Товчилсон үг	Тайлбар
ISO	Олон улсын стандартын байгууллага
ЧУТ	Чанарын удирдлагын тогтолцоо
ЧУХ	Чанарын удирдлагын хороо
ЭБАТ	Эрх бүхий албан тушаалтан
ДХШБ	Дотоодын хяналт шалгалтын баг
АЭМТХАХ	Авлигын эсрэг менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх ажлын хэсэг
АШБ	Анхан шатны бүртгэл
СҮАЖ	Стандарт үйл ажиллагааны журам
ББНС	Баримт бичгийн нэгдсэн сан
ЧГА	Чанарын гарын авлага

3.1 Авлига

ЧГА-ын 1.2-т заасан сүбъект албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхгүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг ойлгоно.

3.2 Байгууллага

Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс

3.3 Сонирхогч талууд

Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагаа, шийдвэр гаргалтад нөлөөлөхүйц, нөлөөнд автагдах эрсдэл бүхий ЧГА-ын 1.2-т заасан сүбъект.

3.4 Шаардлага

а) Авлига, ашиг сонирхлын зөрчил бий болох нөхцөлийг бүрэн арилгасан байх.

б) Авлига, ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд мэдээллийг аюулгүй хүлээн авах тухай “Шүгэл үлээх журам”-ыг баталж, мөрдөн ажиллах.

в) Олон нийтэд авлига, ашиг сонирхлын зөрчлийн хор уршгийн талаар сурталчилан, соён гэгээрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тогтмол хийж хэвшүүлсэн байх

3.5 Менежментийн тогтолцоо

Тухайн жилийн дэвшүүлсэн зорилт, төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг авлига, ашиг сонирхолын зөрчилгүй, хариуцлагатай, ёс зүйтэй хэрэгжүүлэн ажлын хэсгийн боловсруулан гаргаж буй баримт бичиг, үйл ажиллагааг нийт албан хаагчид, нийгмийн даатгалын үйлчилгээ авч буй иргэд, аж ахуйн нэгж, харилцагч байгууллагуудад хүргэж, тэдгээр нь авлигаас ангид байна

3.6 Дээд шатны удирдлага

Авлигын эсрэг менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх “Чанарын удирдлагын хороо”

3.7 Хяналтын бүлэг

Авлигын эсрэг менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх “Дотоод хяналт, шалгалтын баг”

3.8 Авилгатай тэмцэх ажлын эрх бүхий албан тушаалтан



Нийгмийн даатгалын хэлтсийн даргын тушаалаар баталсан хүний нөөц, тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн нь авлигатай тэмцэх эрх бүхий албан тушаалтан байна.

ЭБАТ нь авлигатай тэмцэхэд дагаж мөрдөх үүргийг хэрэгжүүлэх ур чадвартай, байр суурьтай, удирдахуйц шинж чанартай, бие даасан албан хаагч байна.

3.9 Үр ашиг

Авлигын эсрэг менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх ажлын хэсгийн төлөвлөгөөг жил бүр боловсруулан ажиллаж, үр дүнгийн үнэлгээг 90 доошгүй хувиар биелүүлнэ.

3.10 Бодлого

Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь авлигын эсрэг баталсан хууль, тогтоол, шийдвэр, журмыг сахин биелүүлж, авлигын эсрэг менежментийн тогтолцоонд байнгын сайжруулалт хийн, даатгуулагчийн эрх ашгийг хүндэтгэсэн, авлигын аливаа хэлбэрийг үл тэвчин авлигагүй бүс болно.

Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн авлигын эсрэг менежментийн ажлын хэсгийн боловсруулсан тухайн жилийн дэвшүүлсэн зорилт, төлөвлөгөө удирдамжийг “Чанарын удирдлагын хороо” батлан, “Дотоод хяналт, шалгалтын баг” хэрэгжилтийг хянан, заавар, зөвлөгөө өгч ажиллана.

3.11 Зорилго

Даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэхдээ авлига, ашиг сонирхолын зөрчилгүй, хариуцлагатай, ёс зүйтэй төрийн байгууллага байна.

3.12 Эрсдэл

а) Хууль, эрх зүйн баримт бичиг өөрчлөгдөх, алдаа дутагдалтай байхаас тодорхойгүй байдал үүсэх

б) Олон нийтэд авлига, ашиг сонирхлын зөрчлийн хор уршгийн талаар сурталчилан, соён гэгээрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь үр дүнгүй нөхцөл байдлаас үүсэн иргэд, аж ахуйн нэгжийн зан үйл, сөрөг үзээгдэл буурахгүй байх

в) Байгууллагын бүтэц, орон тоо, ажлын чиг үүрэг, хэсэгчлэн болон бүрэн өөрчлөгдөх, техникийн саатал зэргээс үл ойлгогдох байдал үүсэх

г) Шүгэл үлээх үйл ажиллагаанд худал мэдээлэл ирүүлэх, гүтгэх, хангалттай нотлох баримтгүй байх, өнгөлөн далдлах зэргээс шалтгаалж авлигын үнэн бодит нөхцөлийг тогтоож чадахгүй байх

3.13 Чадамж

Авлигын эсрэг менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх ажлын хэсэг нь нийт албан хаагчдад авлига, ашиг сонирхлын зөрчлийн хор уршгийн талаар сурталчилан, соён гэгээрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг таниулж, авлигын эсрэг менежментийн тогтолцооны гарын авлагыг өдөр тутмын үйл ажиллагаандаа баримтан ажиллах

3.14 Баримтжуулсан мэдээлэл

Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн удирдлагын хянан баталгаажуулсан авлигын эсрэг менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх ажлын хэсгийн боловсруулан гаргаж буй авлигын эсрэг үйл ажиллагаатай холбоотой цахим болон бичгийн баримтууд

3.15 Үйл явц



Авлигын эсрэг менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх ажлын хэсгийн боловсруулан гаргаж буй баримт бичиг, үйл ажиллагаа нь нийт албан хаагчид, нийгмийн даатгалын үйлчилгээ авч буй иргэд, аж ахуйн нэгж, харилцагч байгууллагуудад хүрч, тэдгээр нь авлигаас ангид байх

3.16 Гүйцэтгэл

Авлигын эсрэг менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх ажлын хэсгийн батлагдсан төлөвлөгөө, үйл ажиллагаа тус бүрийн хүрэх түвшин, үр дүнгээр хэмжигдэнэ.

3.17 Гэрээгээр гүйцэтгүүлэх

Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь авлигын эсрэг үйл ажиллагаатай холбоотой цахим болон бичгийн баримтуудыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэхэд орон нутгийн болон улсын чанартай холбогдох байгууллагатай гэрээ байгуулан хэрэгжүүлж болно.

3.18 Хяналт, шинжилгээ

Авлигын эсрэг менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх ажлын хэсгийн боловсруулан гаргаж буй баримт бичиг, үйл ажиллагааг авлигын эсрэг менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх “Дотоод хяналт, шалгалтын баг” жилд 2 удаа хянан дүгнэж, заавар зөвлөгөө өгөх

3.19 Хэмжих

Авлигын эсрэг менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх ажлын хэсгийн боловсруулан гаргаж буй баримт бичиг, үйл ажиллагаа нь нийт албан хаагчид, нийгмийн даатгалын үйлчилгээ авч буй иргэд, аж ахуйн нэгж, харилцагч байгууллагуудад хүрч, тэдгээрээс авлигын эсрэг гомдол мэдээлэл гаргалгүй ажиллах

3.20 Аудит

Авлигын эсрэг менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх үйл явцад бусад байгууллагаас болон “Дотоод хяналт, шалгалтын баг” дотоод аудитын үүрэг гүйцэтгэж, аудитын нотлох баримт, шалгуур үзүүлэлт зэргийг ISO 19011-д тодорхойлсноор хянан шалгана.

3.21 Тохирох

а) Авлига, ашиг сонирхлын зөрчил бий болох нөхцөлийг бүрэн арилгахын тулд эрсдлийг тооцоолж, бууруулах арга хэмжээ авч, үр дүнг тооцон ажилласан байна.

б) Авлига, ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд мэдээллийг аюулгүй хүлээн авах тухай “Шүгэл үлээх журам”-ыг баталж, цахим болон бусад хэлбэрээр тухай бүрт мэдээллийг тасралтгүй хүлээн авч, шийдвэрлэх эрх бүхий байгууллагад шилжүүлэн ажиллана.

в) Олон нийтэд авлига, ашиг сонирхлын зөрчлийн хор уршгийн талаар сурталчилан, соён гэгээрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хэрэгжилтийг тогтмол баримтжуулан тайлагнаж, сэтгэл ханамжийн судалгаагаар үр дүнг тооцон ажилласан байна.

3.22 Үл тохирох

ЧГА-н 3.21-д заасан нөхцлийг хангаагүй байдал

3.23 Залруулах ажиллагаа

Авлигын эсрэг менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх үйл явцад бусад байгууллагаас болон ДХШБагаас хийсэн хяналт шалгалтаар илэрсэн ЧГА-н 3.21-д заасан үл тохирлыг эрх бүхий албан тушаалтан бүртгэл хөтлөн, ЧУХ-д мэдээлж, авлигын эсрэг менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх ажлын хэсэгт чиглэл өгч дахин гарахаас урьдчилан сэргийлж ажиллана



3.24 Байнга сайжруулах

Авлигын эсрэг менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх ажлын хэсгийн батлагдсан төлөвлөгөө, үйл ажиллагаа тус бүрийн хүрсэн үр дүнг жилийн эцэст ЧУХ хэлэлцэн үнэлгээ, дүгнэлт өгч ажиллана.

3.25 Ажилтан

Нийгмийн даатгалын хэлтсийн дарга, тасгийн дарга, байцаагч, албан хаагч, үйлчилгээний албан хаагч, гэрээт ажилтан, төлөөлөгчид хамаарна.

3.26 Бизнесийн холбоотон

Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, шат дамжлагыг багасгах, нээлтэй ил тод байдлыг хангах, авлига гарах шалтгаан нөхцөлийг бууруулах зорилтын хүрээнд төрийн болон төрийн бус олон нийтийн байгууллагуудтай хуулийн хүрээнд нээлттэй хамтран ажиллаж болно.

3.27 Нийтийн албан тушаалтан

Төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан, болон ерөнхий нягтлан бодогч,

3.28 Гуравдагч тал

Ёс зүйн зөвлөл, Гомдлын шаардлагын зөвлөл, Баян-Өндөр сумын малчны зөвлөл, Эрх бүхий албан тушаалтан

3.29 Ашиг сонирхолын зөрчил

Нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед түүний хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдал.

3.30 Мэргэжлийн судалгаа

Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтнаас ЧГА-н 3.12-д заасан эрсдэлийн шинж чанар, хэр хэмжээг тогтоох, онцгой гүйлгээ, төсөл, үйл ажиллагаа, болон хуулийн хүрээнд нээлттэй хамтран ажиллаж болох төрийн болон төрийн бус олон нийтийн байгууллагуудтай холбоотой шийдвэр гаргахад ЭБАТушаалтнаас тэдгээрийг авлигаас ангид байлгахад мэргэжлийн судалгаа хийн, дүгнэлт гарган туслах үйл явц байна.

Шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан өөрийн гаргасан шийдвэрийн төслөө ЭБАТушаалтанд танилцуулж, баталгаажуулна.

ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

4.1. Байгууллага болон түүний төлөв байдлыг ойлгох

Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн авлигын эсрэг менежментийн тогтолцооны хүрээнд зорьсон үр дүнд хүрэх, зорилтоо хэрэгжүүлэх боломж, стратеги чиглэлд хамааралтай гадаад, дотоод асуудлыг ийнхүү тодорхойлно.

SWOT шинжилгээ

Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь байгууллагын төлөв байдлыг үнэлэн дотоод хүчин зүйлийг давуу болон сул тал, гадаад хүчин зүйлийг аюул болон боломж гэж шинжилнэ.



Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none">• Ажлын хамт олон зохих түвшинд зөв төлөвшсөн, мэдлэг ур чадвар сайн, нэг ажлаас нөгөөд хөрвөх чадвартай• Удирдлагын баг сайн бүрдсэн ба өөрчлөлт шинэчлэлт, менежментийг дэмждэг.• Нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлдэг тул иргэдийн хандлага сайн даатгуулагчдын тоо өсөх хандлагатай• Техник тоног төхөөрөмж, программ хангамж сайн• Хүн бүрийн хийх ажлын чиг үүрэг тодорхой, ажил тогтмолжсон• Байгууллагын дотоод орчны зохион байгуулалт сайн• Жишиг архивтай	<ul style="list-style-type: none">• Хүний нөөцийн дутагдал• Програм хангамж сайн хэдий ч дээд шатны байгууллага, төрийн байгууллагын хоорондын уялдаа холбоо муу• Цалин хангамж, урамшууллын тогтолцоо сул• Шинэ ажилчдын сургалт, хөгжлийн асуудал дутмаг• Хэвлэл мэдээллийн хэрэгслээр реклам, сурталчилгаа муу цацагддаг• Байгууллага, даатгуулагчийн өмчийг хамгаалах ажил сул• Олон жил хэвшсэн төрийн албаны арга барил өөрчлөгдөхдөө удаан байх
Боломж	Аюул
<ul style="list-style-type: none">• Чадварлаг мэргэшсэн баг бүрдүүлэх боломжтой• Хариуцлага, урамшуулалын систем нэвтрүүлэх боломжтой• Иргэд даатгуулагчдын хандлагыг өөрчлөх, Нийгмийн даатгалын тухай хуулийн мэдлэгээр хангах боломжтой• Хамрагдалтыг нэмэгдүүлэх боломжтой• Гадаад харилцааг өргөжүүлэх, туршлага солилцох боломжтой• Үйл ажиллагааны процессыг хөнгөвчлөх боломжтой.• Нийгмийн даатгалын шинэлэг үйлчилгээ, орчин үеийн менежмент нэвтрүүлэх боломжтой.	<ul style="list-style-type: none">• Эдийн засгийн хямрал• Авлига өгөхийг оролдох• Бухимдсан иргэд даатгуулагч байцаагчдад халдах• Нийгмийн даатгалын тогтолцоонд улс төрийн оролцоо нэмэгдэх• Даатгуулагч итгэл алдрах, гомдол гаргах• Иргэд нийгмийн даатгалын талаар буруу мэдээлэл авах бусдад дамжуулах, даатгуулагч хохирох• Интернэт, цахим сүлжээгээр эх сурвалж тодорхойгүй, худал мэдээлэл тархах• Байцаагчийн зохимжгүй үйлдлээс шалтгаалан байгууллагын нэр хүнд унах• Байцаагчийн ёс зүйн хэм хэмжээ зөрчигдөх нөлөөлөл бий болох

4.2. Сонирхогч талуудын хэрэгцээ шаардлагыг ойлгох

Сонирхогч тал гэдэгт ЧГА-ын 1.2-т заасан сүбъектүүдийг ойлгоно.

Тэдгээрийн шаардлага, хүлээлтийг судалгаагаар тодорхойлж, үр дүнд үндэслэн эрсдлийг тооцоолж, шаардлагатай арга хэмжээг төлөвлөнө.

4.3. Авилгатай тэмцэх ажлын менежментийн тогтолцооны хамрах хүрээг тодорхойлох



Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь байгууллагын төлөв байдлыг үнэлэн дотоод хүчин зүйлийг давуу болон сул тал, гадаад хүчин зүйлийг аюул болон боломж гэж шинжилнэ

Сонирхогч тал гэдэгт ЧГА-ын 1.2-т заасан сүбъектүүдийг ойлгоно.

Тэдгээрийн шаардлага, хүлээлтийг судалгаагаар тодорхойлж, үр дүнд үндэслэн эрсдлийг тооцоолж, шаардлагатай арга хэмжээг төлөвлөнө.

4.4 Авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцоо

Нийгмийн даатгалын үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах нь нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны үндсэн зарчим юм.

Энэхүү зарчмыг хэрэгжүүлэх албан тушаалтан нь хууль дээдлэх зарчимд захирагдан, албан үүргээ иргэдийн итгэл хүлээхүйц, тэгш, шударга, хариуцлагатайгаар гүйцэтгэж, албаны ёс зүйг сахих байдлыг хангаж ажиллахад нийгмийн даатгалын үйлчилгээнд хамаарах бүхий л процессуудыг тодруулан тэдгээрийн харилцан үйлчлэл ба хамаарлыг тодорхойлсоноор ажилтнуудын үүрэг оролцоо, хариуцлага, нэгж хэсгүүдийн уялдаа холбоо, хамтын ажиллагаа сайжран, ажлын чанарыг дээшлүүлэн авлигын бүх зөрчлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг танин тодорхойлох, үнэлэхэд чиглэсэн байна.

4.5 Авлигын эрсдлийг үнэлэх

4.5.1 “Авлигын эрсдэлийн үнэлгээний тухай” журмын дагуу АЭМТХАХ нь авлигын эрсдлийг жилд 1 удаа хийнэ.

а) Эрсдэлийн үнэлгээг байгууллагын үйл ажиллагааны дараах чиглэлээр тусгайлан зохион байгуулна.

1. Байгууллагын чиг үүрэг, бүтэц
2. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа
3. Хүний нөөцийн удирдлага
4. Үйл ажиллагаа, шийдвэр гаргах үйл явц
5. Ил тод байдал
6. Ёс зүйн болон шударга ёсны тогтолцоо
7. Хариуцлагын механизм
8. Шийтгэл оногдуулах механизм

б) Тодорхойлсон авлигын эрсдлүүдэд задлан үр дагавар, учирч болох магадлалын үзүүлэлтээр дүн шинжилгээ хийж эрсдэлийн үнэлгээний түвшинг тогтооно.

в) Эрсдэлийн үнэлгээний түвшингийн үр нөлөөг үнэлэж, хяналт хийж авлигын эрсдлийг бууруулах тохиромжтой ажлын төлөвлөгөө боловсруулах үзүүлэлтийг тогтооно.

4.5.2 Нийгмийн даатгалын байгууллага авлигын эрсдэлийг үнэлэн дүгнэх шалгуур үзүүлэлтийг өөрийн бодлого, зорилтын үндсэн дээр тухай бүр шинэчлэх, өөрчлөн тогтоож тухай бүрт “Авлигын эрсдэлийн үнэлгээний тухай” журамд тусгасан байна.



4.5.3 Авлигын эрсдэлийн үнэлгээний дүн шинжилгээнд нөлөөлөхүйц тохиолдол бүрт “Авлигын эрсдэлийн үнэлгээний тухай” журамд заасан үнэлгээний баг өөрчлөлтийн эрсдэлийн үнэлгээг хийнэ.

а) Нийгмийн даатгалын байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдсан

б) Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа, бүтцэд томоохон өөрчлөлт орох

4.5.4 Нийгмийн даатгалын байгууллага авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцооны дагуу авлигын эрсдэлийг үнэлэх явцад “Авлигын эрсдэлийн үнэлгээний тухай” журамд заасны дагуу баримтжуулан, бүртгэл хөтөлж, зөвлөмж гаргана.

ТАВ. МАНЛАЙЛАЛ

5.1. Манлайлал ба амлалт

5.1.1. Хяналтын бүлэг

Авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцоог хэрэгжүүлж байгаа хяналтын бүлэг болох “Дотоод хяналт, шалгалтын баг” нь дараах манлайлал, амлалтыг хэрэгжүүлнэ.

а) Байгууллагын, авлигатай тэмцэх бодлогыг хүлээн зөвшөөрөх

б) Авлигатай тэмцэх бодлого, стратегийн уялдааг хангана

в) Авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцооны төлөвлөсөн хуваарийн дагуу хийж буй байгууллагын ажил, мэдээллийн агуулгыг хүлээн авч, үнэлэх

г) Авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцоог үр ашигтай хэрэгжүүлэхийн тулд шаардлагатай нөөцийг хангалттай хуваарилсан зохистой эх сурвалж ашигласан, эсэхийг анхаарах

д) Авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцооны талаар мэдлэг, мэдээлэлтэй байж хянана

5.1.2. Дээд шатны удирдлага

Авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцоонд ЧУХ нь дараах манлайлал, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

а) авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцооны бодлого, зорилт, хэрэгжүүлэх явц, гүйцэтгэлийг хангах, зохих байгууллагын авлигын эрсдэлийг хянах

б) авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцооны шаардлага, байгууллагын ажлын явцтай таарч, нэгдэж байгаа эсэхийг хянах

в) авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцоо зохистой нөөцөд тулгуурлан үр ашигтай ажиллаж байгаа эсэхийг хянах

г) авлигатай тэмцэх бодлогын гадаад болон дотоод харилцааг хянах

д) авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцооны шаардлагын дагуу гадаад харилцааны бодлогод уг менежментийг үр өгөөжтэй нийцүүлэх

е) авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцооны “даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэхдээ авлига, ашиг сонирхолын зөрчилгүй, хариуцлагатай, ёс зүйтэй төрийн байгууллага байна” гэсэн зорилгодоо нийцэн тохирсон эсэхийг хянах

ё) авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцоо хувь хүнийг дэмжиж, шууд нөлөөлж, үр өгөөжтэй байгаа эсэх



ж) байгууллагад тохирсон, авлигатай тэмцэх ажлын ёс суртахуун, соёл төлөвшүүлэх; байнгын сайжралыг идэвжүүлэх

з) тогтолцооны агуулга, ажил хэрэг, хэрэгжих нөхцөлөөр хангаж, бусад холбогдох удирдах чиг үүргийг дэмжих зэргээр өөрийн хариуцлагын хүрээнд манлайллыг авлигын хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэхэд чиглүүлэх

и) авлигын хэрэг үйлдсэн, эсвэл, сэжиглэгдэж буй гэж үзвэл мэдээлэх журмыг урамшуулах

й) хувь хүн доромжлол хүчирхийлэлд оролцсоноос бусад тохиолдлоор авлигатай тэмцэх бодлогыг зөрчсөн, эсвэл, хэрэгжүүлэхээс татгалзсан тохиолдлыг байгууллагын ажилтан сайн дурын үндсэн дээр санаатай болон санамсаргүй мэдээлсэн тохиолдолд ял шийтгэл оноохгүй бөгөөд ялгаварлан гадуурхаж, сахилга батын болон өөр бусад шийтгэл ноогдуулахгүй

к) авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцооны болон ноцтой буюу зохион байгуулалттай авлигын үндэслэл нотолгоог тухай бүрт “Дотоод хяналт, шалгалтын баг” тайлагнана.

5.2. Авлигатай тэмцэх бодлого

ЧУХ нь авлигын эсрэг баталсан хууль, тогтоол, шийдвэр, журмыг сахин биелүүлж, авлигын эсрэг менежментийн тогтолцоонд байнгын сайжруулалт хийн, даатгуулагчийн эрх ашгийг хүндэтгэсэн, авлигын аливаа хэлбэрийг үл тэвчин авлигагүй бүс болох бодлогыг үнэлж, хэрэгжүүлэх ёстой. Үүнд:

а) авлигыг хориглох

б) авлигын эсрэг холбогдох хууль тогтоомж байгууллага дээр хэрхэн хэрэгжиж буйг хянах

в) байгууллагын зорилгодоо нийцэж байгаа эсэхийг хянах

г) авлигатай тэмцэх зорилтыг хангаж, тогтоож, хянаж байгаа эсэхийг хянах

д) авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцооны шаардлага, амлалтыг хангаж, багтааж байгаа эсэхийг хянах;

е) санаатай болон санамсаргүй, сайн дурын үндсэн дээр, өс хонзонгоос айлгүйгээр гомдол мэдүүлэхийг дэмжих

ё) авлигатай тэмцэхэд дагаж мөрдөн хэрэгжүүлэх ажил, чадамж, бие даасан шинж чанарыг тодорхойлох

ж) авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцоотой үл нийцэх үр дагаврыг танилцуулах

з) АЭМТХАХ, ДХШБ, ЭБАТ нарын авлигын эсрэг хэрэгжүүлэх ажил, чадамж, хараат бусаар бие даасан шинж чанартай байгаа эсэхийг хянах

и) авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцооны байнгын сайжруулалтын арга хэмжээний үр дүнг дүгнэх

5.3. Байгууллага дахь үүрэг, хариуцлага, эрх мэдэл

5.3.1 Үүрэг хариуцлага

Авлигын эсрэг үйл ажиллагааны баримт бичгүүдэд үүрэг хүлээсэн баг, албан хаагчийн буруутай үйлдэл, эс үйлдэл болон зөрчлийг ДХШБаг тогтоон илрүүлнэ.

ДХШБаг авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцооны хэрэгжиж буй талаар ЭБАТ-д мэдээлэх үүрэгтэй



ЧУХ нь авлигатай тэмцэх менежментийн тогтолцооны ЧГА-н 5.1.2-т заасныг даган мөрдөж, үүрэг, холбогдох хариуцлагыг ханган ажиллана.

ЧУХ нь хариуцлага, эрх бүхий зохион байгуулалтын бүх төвшинд холбогдох үүргийг оноож, хариуцлага, эрх мэдлийг олгож, мэдээллээр хангаж, зохих дүрэм журмын гүйцэтгэлийг хянан ажиллана.

АЭМТХАХэсгийн дарга нь тухайн жилийн дэвшүүлсэн зорилтдоо нийцүүлж төлөвлөгөө, удирдамжийг боловсруулж, ЧУХороогоор батлуулан, ажлын хэсгээр гүйцэтгүүлнэ

Тасгийн дарга нар авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцооны шаардлагыг өөрийн тасаг, нэгжид гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган, үүрэг болгон тогтоож, АЭМТХАХэсгийн төлөвлөгөөнд заасан авлигын эсрэг үйл ажиллагааг дэмжин, гүйцэтгүүлэн хэрэгжүүлнэ.

ДХШБ, ЧУХ, АЭМТХАХ, бусад бүх албан хаагч, төлөөлөгчид нь байгууллага дахь өөрсдийн үүрэгтэй уялдаатайгаар авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцооны шаардлагуудыг ойлгох, нийцэх, хэрэглэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Авлигын эсрэг үйл ажиллагааны баримт бичгүүдэд үүрэг хүлээсэн баг, албан хаагчийн буруутай үйлдэл, эс үйлдэл болон зөрчлийг холбогдох баг, албан тушаалтанд ЧУХ хариуцлага тооцно.

5.3.2 Авлигатай тэмцэх ажлын эрх бүхий албан тушаал

ЧУХ нь ЭБАТ-ын авлигатай тэмцэхэд гүйцэтгэхэд үүрэг, эрх мэдлийг тогтоон зааж өгнө. Үүнд:

- а) авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцоог байгууллага хэрэгжүүлж байгаа эсэхийг хянана
- б) авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцоо болон авлигатай холбоотой асуудлаар хувь хүнд мэдээлэл зөвлөгөө өгч, удирдамжаар хангана
- в) авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцоо энэхүү баримт бичгийн шаардлагатай нийцэж, хангаж байгаа эсэхийг хянана
- г) авлигын эсрэг менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх үйл явцад бусад байгууллагаас болон ДХШБагаас хийсэн хяналт шалгалтаар илэрсэн ЧГА-н 3.21-д заасан үл тохирлыг эрх бүхий албан тушаалтан бүртгэл хөтлөн, ЧУХ-д мэдээлж, авлигын эсрэг менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх ажлын хэсэгт чиглэл өгч дахин гарахаас урьдчилан сэргийлж ажиллах үүрэгтэй
- д) Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтнаас ЧГА-н 3.12-д заасан эрсдэлийн шинж чанар, хэр хэмжээг тогтоох, онцгой гүйлгээ, төсөл, үйл ажиллагаа, болон хуулийн хүрээнд нээлттэй хамтран ажиллаж болох төрийн болон төрийн бус олон нийтийн байгууллагуудтай холбоотой шийдвэр гаргахад ЭБАТушаалтнаас тэдгээрийг авлигаас ангид байлгахад “Авлигын эрсдлийн үнэлгээний журам”-ын дагуу мэргэжлийн судалгаа хийж, дүгнэлт гарган туслах үүрэг хүлээнэ
- е) авлигатай тэмцэх ажлын эрх бүхий албан тушаалтан нь авлига болон авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцоотой холбоотойгоор үүссэн аливаа асуудлаар шаардлага тулгармагц ДХШБ болон ЧУХ-ны удирдлагад шууд, нэн даруй мэдээлэх үүрэгтэй
- ё) авлигатай тэмцэх менежментийн тогтолцооны баримт бичгийн бүртгэл хөтөлж, бүрэн бүтэн байдлыг хангах, хадгалах, архивлах үүрэгтэй



ж) Дээд шатны байгууллагаас ирүүлсэн авлигын эсрэг үйл ажиллагаатай холбоотой тайлан мэдээг нэгтгэн тухай бүрт үнэн зөв гарган ЧУХ-ны удирдлагад хянуулан, илгээх үүрэгтэй

з) “Шүгэл үлээх журам”-ын дагуу ирсэн өргөдөл, гомдол, мэдээлэл, санал, хүсэлтийг хүлээн авч, бүртгэл хөтлөн, зохих ажиллагааг хийх үүрэгтэй

д) Нийт ажилтан албан хаагчдын чадамжуудыг нотлох холбогдох баримтжуулсан мэдээллийг хөтөлж, хадгалах үүрэгтэй.

5.3.3 Шийдвэр гаргах ажлыг төлөөлөх

Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга нь ЧГА-н 5.3.1-д зааснаар авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцооны ажиллах, хэрэгжих нөхцөлийг хангах бүх нөөц боломжоор хангаж ажиллах бөгөөд ЧГА-н 5.1.1, 5.1.2, 5.3.1-т зааснаар ЧУХ болон ДХШБагийн эрх үүрэгт халдаж болохгүй.

ЗУРГАА. ТӨЛӨВЛӨЛТ

6.1 Эрсдэл болон боломжийг авч үзэх арга хэмжээ

Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцоог төлөвлөн ажиллахдаа гадаад болон дотоод хүчин зүйлийг анхаарч, сонирхогч талуудын хэрэгцээ шаардлага, хүлээлтийг судалгаагаар тодорхойлж, үр дүнд үндэслэн эрсдлийг тооцоолж, шаардлагатай арга хэмжээг төлөвлөнө. “Авлигын эрсдэлийн үнэлгээний тухай” журмын дагуу эрсдлийг илрүүлэх, боломж, сайжруулалтыг тогтоож олно. Ингэхдээ дараахийг анхаарна. Үүнд:

а) авлигатай тэмцэх бодлого зорилтод тооцоолоогүй саад, нөлөөнөөс урьдчилан сэргийлэх, бууруулах,

б) авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцооны нөлөөнд эрсдлийн хяналт, шинжилгээ хийх

в) авлигын эсрэг үйл ажиллагааны байнгын сайжруулалтын үр нөлөөнд эрсдлийн хяналт, шинжилгээ хийх

6.2. Авлигатай тэмцэхээр дэвшүүлсэн зорилт, түүнд хүрэхэд чиглэсэн ажлыг төлөвлөх

Нийгмийн даатгалын байгууллагын авлигатай тэмцэх зорилт:

а) Нийгмийн даатгалын байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоо, итгэх итгэлийг нэмэгдүүлэх, сонирхогч талуудын хамтын ажиллагааг авлигаас ангид байхад чиглэсэн үйл ажиллагаа явуулж, үр дүнг тогтмол хэмжиж, байнгын сайжруулалтыг хийнэ

б) Авлигын эсрэг хэрэгжүүлж буй үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангаж хариуцлагыг нэмэгдүүлнэ.

в) Олон нийтэд авлига, ашиг сонирхлын зөрчлийн хор уршгийн талаар сурталчилан, соён гэгээрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тогтмол хийж, эерэг нөлөөг бий болгоно



г) ОУ-н болон МУ-н хэмжээнд авлигын эсрэг үйл ажиллагаа явуулж буй бусад аж ахуйн нэгжийн тэргүүн туршлагаас суралцаж, өөрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг хөгжүүлэн шинэчлэнэ

Авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцооны зорилгодоо хүрэхийн тулд дараах үйл ажиллагааг дагаж мөрдөнө. Үүнд:

- АЭМТХАХ нь тухайн жилийн 1-р улирлын сүүлийн сарын 15-ны өдрөөс өмнө шаардлагатай нөөц, хариуцах эзэн, хэрэгжүүлэх хугацааг болон авлигатай тэмцэх зорилтыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж ЧУХ-р батлуулна
- ЧУХ тухайн жилийн 4-р улирлын сүүлийн сарын 15-ны дотор АЭМТХАХ-ийн төлөвлөсөн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэн, дүгнэнэ.
- Авлигын эсрэг үйл ажиллагааны баримт бичгүүдэд үүрэг хүлээсэн баг, албан хаагчийн буруутай үйлдэл, эс үйлдэл болон зөрчлийг тогтоон илрүүлж, холбогдох баг албан тушаалтанд хариуцлага тооцож ажиллана.

ДОЛОО. ТУЛГУУР ХҮЧИН ЗҮЙЛ

7.1. Нөөц

7.1.1. Хүний нөөц

Нийгмийн даатгалын хэлтсийн дарга, тасгийн дарга, байцаагч, албан хаагч, үйлчилгээний албан хаагч, төлөөлөгчид хамаарна.

7.1.2 Материаллаг нөөц

Авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцоо, үүргийг үр өгөөжтэй хэрэгжүүлэхийн тулд дараах материаллаг нөөцийг ашиглана.

1) Барилга ба дагалдах байгууламжууд:

Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 348 м.кв барилга.

2) Тээврийн хэрэгсэл:

HYUNDAI ELANTRA маркын автомашин.

3) Мэдээлэл ба харилцаа холбооны технологи:

Монголын цахилгаан холбоо, Мобинет, Юнивишн зэрэг байгууллагын интернетийн эх үүсвэр

4) Тоног төхөөрөмж, материал ба тавилга:

71 төрлийн тоног төхөөрөмж, 23 нэр төрлийн эд хогшил

5) Програм хангамж:

Гадаад орчны буюу вэб програмууд:

- | | |
|------------------------------|---|
| --- Хүний нөөцийн программ | - http://10.9.0.5/hresource/ |
| --- Нэгдсэн лавлагаа | - http://10.9.11.2:808/ndlav/Login.aspx |
| --- Даатгуулагчийн мэдээлэл | - http://www.ndaatgal.mn/regnd/ |
| --- Албаны e-мэйл | - https://mail.ndaatgal.mn/webmail/login/ |
| --- Зар мэдээ | - http://10.9.0.5/zarmedee/ |
| --- Хэрэглэгчийн програм | - http://10.9.0.5/nduser/ |
| --- Тэтгэвэр тогтоолт шалгах | - http://www.ndaatgal.mn/tet/ |
| --- Байгууллагын эрх олгох | - http://10.9.11.2/onlineshim/master/ndlog/login.aspx |
| --- Шимтгэлийн цахим систем | - https://app.ndaatgal.mn/onlineshim/ |
| --- Нэрийн данс шалгах | - http://www.ndaatgal.mn/ndans |



- Нэрийн данс - <http://10.9.0.5/ndans>
- Төсвийн төсөөллийн програм - <http://10.9.0.5/budget/>
- Тэтгэвэр олголтын хяналтын програм - <http://10.9.0.5/tetcheck/>
- Сайн дурын даатгалын програм - <https://app.ndaatgal.mn:811/sd/login.aspx>
- Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох програм - <http://10.9.0.5/refund/>
- Нөхөн олговрын програм - <http://10.9.0.5/refundHun/>
- Нөхөн тооцох, нөхөн олгоорт хамрагдсан хүмүүсийн мэдээлийн програм - <http://www.ndaatgal.mn/rfcheck/>
- ЭХМК-ийн цахим програм - <https://app.ndaatgal.mn:811/ehmkweb/>

Дотоод орчны програм:

- Шимтгэлийн тооцооны программ - [deduction.exe](#)
- Эрүүл мэндийн даатгалын орлогын програм - [emd.exe](#)
- Эрүүл мэндийн даатгалын зардлын програм - [his.exe](#)
- Тэтгэмжийн тооцооны програм - [tetgemj.exe](#)
- Тэтгэврийн тооцооны програм - [pension.exe](#)
- Сангийн харилцахын програм - [hariltsah.exe](#)
- Сангийн сарын мэдээний програм - [sarmedee.exe](#)
- ЭХМК-ын програм - [HealthCommittee.exe](#)
- Хавсралтын нэгтгэлийн програм - [unite.exe](#)
- ҮОМШӨ-ний даатгалын програм - [uorsz.exe](#)
- Үйл ажиллагааны санхүүгийн програм - [Sanhuu.exe](#)

7.1.3. Санхүүгийн нөөц

Төрийн албаны тухай хуулийн заалтын дагуу ажилтанд шаардлагатай шийдвэрлэх хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган шийдвэрлэж байна.

7.2 Чадамж

Авлигатай тэмцэх менежментийн тогтолцооны үйл ажиллагааг хэрэгжүүлэх үр дүнд хүрэхийн тулд мэдлэг, ур чадвараа ашиглах чадварыг хэлнэ.

7.2.1 Ерөнхий зүйл

ДХШБагийн гишүүд нь төрийн албан хаагчийн нийтлэг болон тусгай шаардлагыг хангасан, улсын байцаагчийн эрхтэй албан хаагчид байна.

ЧУХорооны гишүүд нь Хэлтсийн дэргэдэх даргын зөвлөлийн гишүүд байх ба бусад авлигын эсрэг менежментийн тогтолцооны бүрэлдэхүүнд харьяалагдаагүй албан хаагч байна.

АЭМТХАХэсгийн гишүүд нь ДХШБ, ЧУХ, ЭБАТ-д харьяалагдаагүй улсын байцаагч, албан хаагч, төлөөлөгч байна.

ЭБАТ нь авлигатай тэмцэхэд дагаж мөрдөх үүргийг хэрэгжүүлэх ур чадвартай, байр суурьтай, удирдахуйц шинж чанартай, бие даасан, ДХШБ, ЧУХ, АЭМТХАХэсэгт харьяалагдаагүй албан хаагч байна.

Авлигын эсрэг менежментийн тогтолцоог хэрэгжүүлж буй албан хаагчдад зохих чадамж эзэмшүүлэх, туршлагажуулах, тодорхой төрлийн эрхийн гэрчилгээ олгох эрх бүхий сургалтад хамруулах асуудлыг “Авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх журам”-д зааснаар зохицуулж, нотлох баримтжуулсан мэдээллийг тухайн албан хаагчийн хувийн хэрэгт хадгална.р

7.2.2 Ажил хөдөлмөр эрхлэх үйл явц



7.2.2.1 Авлигатай тэмцэх бодлого, авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцооны шаардлагад нийцсэн “Авлигын эсрэг үйл ажиллагааны журам”-д хөдөлмөр эрхлэх нөхцлийг бүрдүүлэх, үл тохирол гарсан тохиолдолд ажилтанд авах арга хэмжээний талаар тусгах, авлигатай тэмцэх бодлогын баримт бичигтэй танилцах, сургалтад хамрагдах нөхцлөөр хангах тухай, авлигатай тэмцэх менежментийн тогтолцоог зөрчсөн ажилтанд хүлээлгэх хариуцлагын тухай, мөн арга хэмжээгээр зөрчил хүлээлгэж болохгүй тохиолдлуудын тухай тусгасан байна.

7.2.2.2 Авлигын эрсдлийн үнэлгээг тодорхойлох “Авлигын эрсдэлийн үнэлгээний тухай” журамд дараах заалтуудыг тусгаж, ханган хэрэгжүүлнэ:

а) ажлын байрны тодорхойлолтод заасан албан тушаал бүрт тохирсон эрсдлийг үнэлэх аргачлалын дагуу эрсдлийн үнэлгээ хийсэн байна.

б) хувь хүнийг ажилд авах, ажилтныг өөр албан тушаалд шилжүүлэх, тушаал дэвшүүлэхийн өмнө, тухайн албан тушаалд зохимжтой эсэхийг үндэслэлтэйгээр тодорхойлох, тэднийг авлигатай тэмцэх бодлого, авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцооны шаардлагуудад нийцэн тохирох эсэх талаар итгэл үнэмшлийг үндэслэлтэйгээр олж авах зорилгоор хүн тус бүрт мэргэжлийн судалгаа дүгнэлтийг хийнэ.

в) төрийн албаны тухай хуульд заасан үндсэн цалин хөлснөөс гадна авлигыг хөхүүлэн дэмжихээс урьдчилан сэргийлж чадаж буйн баталгаатай болсон гэдгийн нотолгоо болгож улирал, хагас жил, жил тутамд /тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан/ гүйцэтгэлээр хүрэх үр дүнд хамаарах шагнал урамшуулал олгоно.

г) ажилтан, ЧУХ, ДХШБ зэрэгт тодорхойлсон авлигын эрсдэлийг зохих хугацаанд тогтмол хуваарилалт хийж мэдэгдлийг боловсруулан баримтжуулж ЭБАТ-д хадгална.

7.3. Мэдлэг ойлголт сургалт

“Сургалт, сурталчилгаа хариуцсан комисс” нь АЭМТХАХ-ээс санал авч тухайн жилийн гадаад болон дотогшоо чиглэсэн сургалтын төлөвлөгөөнд авлигатай тэмцэх мэдлэг олгох сургалтыг тусган тогтмол хэрэгжүүлэх ба шинэ гарсан мэдээлэлтэй уялдуулж, сургалтын агуулга, хэнд, хэрхэн, хэзээ сургалт хийснээ баримтжуулан хадгална.

Сургалтад дараах асуудлыг тусгана.

а) авлигатай тэмцэх бодлого, журмууд, авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцоо, шаардлагад нийцэх үүрэг

б) авлигын эрсдэл, авлига гарсны үр дүнд ажилтнууд болон байгууллагад учрах хор хохирол

в) ажилтнуудын ажил үүрэгтэй холбоотойгоор авлига илэрч болох нөхцөл, тэдгээр нөхцлийг хэрхэн ялган таних арга

г) авлигад өдөөн хатгах, санал болгож буйг хэрхэн таних, мэдэх, хариу арга хэмжээ авах

д) авлигаас урьдчилан сэргийлэх, зайлсхийхэд туслах, авлигын эрсдэлийн үнэлгээг хэрхэн хийх

е) авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцоо, авлигатай тэмцэх ажлын гүйцэтгэлийг сайжруулахын ашиг тус, болзошгүй авлигын зөрчлийг мэдээлэхийн ач холбогдол, эдгээр ажилд оролцох ажилтнуудын оролцооны хувь нэмэр

ё) авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцооны шаардлагад үл нийцэх болзошгүй үр дагавар, учир холбогдол

ж) аливаа асуудлыг хэрхэн, хэнд тайлагнан, мэдүүлэх арга зам, мэдээлэх

з) сургалт болон нөөцөд тулгуурласан мэдээлэл



7.4. Холбоо харилцаа

7.4.1 Авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцоог мөрдөхөд Нийгмийн даатгалын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Иргэний хууль, Зөрчлийн тухай хууль, холбогдох бусад хууль, эрх зүйн баримт бичгийн хүрээнд, ажлын байранд болон албан ажлаар хамааралтай объектод ажлын болон ажлын бус цагаар, холбогдох эрх бүхий албан хаагч, ажилтан, төлөөлөгчтэй, шууд /биечлэн/ болон шууд бусаар /бичгээр, цахимаар, утсаар, харилцаа холбооны бусад хэрэгслээр/ ЧГА-н 1.2-т заасан сүбъектүүд нь Монгол хэлээр /хэлмэрч, орчуулагч болон баталгаат орчуулгатай/ харилцана.

7.4.2 Авлигатай тэмцэх бодлогыг ЧГА-н 7.4.1-д заасан харилцаа холбоондоо тохиромжтой байдлаар дагаж мөрдөж болно.

7.5. Баримтжуулсан мэдээлэл

7.5.1. Ерөнхий зүйл

Байгууллагын авлигатай тэмцэх менежментийн тогтолцооны олон улсын MNS ISO 37001:2017 стандарт шаардлагын дагуу баримтжуулан бүх төрлийн мэдээллийг дангаар нь хадгална.

7.5.2. Мэдээлэл бий болгох, шинэчлэх

Нийгмийн даатгалын хэлтэс нь баримтжуулсан мэдээллийг бий болгох, шинэчлэхдээ дараах зүйлийг тусган хэрэгжүүлнэ:

а) Баримт бичгийн нэр, батлагдсан огноо, боловсруулагч, батлагчийн нэр, албан тушаал, индексийн дугаар

б) Мэдээллийг цаасан болон цахим хэрэгслээр зөөх болон хадлалах боломжтой байх

в) Мэдээллийг Монгол хэлээр боловсруулж, бүх төрлийн график, программ хангамжийн хувилбар, бичлэг, аудио, зураг, хүснэгт зэргээр илэрхийлнэ.

7.5.3. Баримтжуулсан мэдээллийг хянах

Олон улсын MNS ISO 37001:2017 стандарт шаардлагын дагуу баримтжуулсан авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцооны мэдээллийг хэрэглэхэд тохиромжтой эсэх, хаана, хэзээ хэрэгтэйг магадлах, зохих хэмжээнд нууц, бүрэн бүтэн байдал хамгаалсан эсэх зэрэг шалгуур үзүүлэлтээр ЧУХ хянана.

Баримтжуулсан мэдээллийг хянахын тулд дараах АЭМТХАХ дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

а) түгээх, олж үзэх, сэргээх, ашиглах нөхцөлийг бүрдүүлэх

б) хадгалах, хамгаалах, гаргацтай байдлыг хадгалах,

в) гадны эх үүсвэр бүхий баримтжуулсан мэдээллийг “Авлигын эсрэг үйл ажиллагааны журам”-д заасны дагуу ялган бүртгэл хөтөлж, хадгалж байгаа эсэхийг хянана.

г) баримтжуулсан мэдээлэлд нэмэлт, өөрчлөлт, шинэчлэлийг “Авлигын эсрэг үйл ажиллагааны журам”-д заасны дагуу хийсэн эсэхийг хянана.

НАЙМ. АЖИЛЛАГАА

Байгууллага нь авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ хийх, төлөвлөх зэрэг үйл явцыг хэрэгжүүлнэ. Үүнд:



- а) Ажлын шалгуур үзүүлэлтийг гаргах
- б) Шалгуур үзүүлэлтийн дагуу хянах үйл явцыг хэрэгжүүлэх
- в) Баримтжуулсан мэдээллийг төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаандаа ашиглана.

Байгууллага нь шаардлагатай бол төлөвлөсөн өөрчлөлтийг хянаж, аливаа сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээ авч, хүсээгүй өөрчлөлтийн үр дагаврыг хянан үзнэ.

8.2. Мэргэжлийн судалгаа

Байгууллагын авлигын эрсдэлийн үнэлгээг хийхдээ ЧГА-н 4.5-д заасан чиглэлийн дагуу жилд 1 удаа 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор байгаа мэдээлэлдээ суурилан, оновчтой, шүүлт хийж дүгнэж болохуйц мэргэжлийн судалгааны тоон үзүүлэлтэд дүгнэлт хийн, үр дүнг үндэслэн авлигын түвшинг тогтооно. Мэргэжлийн судалгааг тухайн ажил үйлчилгээг харьяалан гүйцэтгэдэг тасгийн дарга, ерөнхий нягтлан бодогч, ахлах, хүний нөөц зэрэг холбогдох албан тушаалтнууд “Авлигын эсрэг үйл ажиллагааны журам”-д заасан шаардлагын дагуу боловсруулан гаргана. Үүнд:

- а) төсөл, ажил үйл, гүйлгээг тодорхой ангилах
- б) сонирхогч этгээдүүдийн харилцааг төлөвлөж, ангилах
- в) албан тушаалын тодорхойлолтод заасан ажил тус бүрээр ангилах

Тасаг, нэгжээс гарсан мэргэжлийн судалгааны баримтжуулсан мэдээллийг ЭБАТ-д төвлөрүүлэн хадгалуулна.

8.3 Санхүүгийн хяналт

Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн Санхүү бүртгэлийн тасаг нь нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, хууль тогтоомжид нийцүүлэн хэлтсийн санхүүгийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Санхүүгийн хяналтын менежментийн тогтолцоо нь байгууллагын ажил гүйлгээнээс хамаарах бөгөөд өөрийн санхүүгийн гүйлгээг зохих дүрэм, журам, зааврын дагуу оновчтой удирдан зохион байгуулж, авлигын эрсдлийг бууруулахад чиглэнэ.

- а) Нийгмийн даатгалын орлого, зарлагын гүйлгээг сангийн нягтлан бодогч төлбөрийн даалгаврийг бэлтгэн, бэлтгэсэн гүйлгээний нэр төрөл, харилцах данс, мөнгөн дүн үнэн зөв эсэхийг ерөнхий нягтлан бодогчоор хянуулан, хэлтсийн дарга баталгаажуулсаны дараа гүйлгээ хийгдэнэ.
- б) Хэлтсийн даргын баталсан гүйлгээг сангийн нягтлан бодогч арилжааны банкны мэргэжилтнээр дамжуулан гүйцэтгэнэ.
- в) Төлбөрийн даалгаврын баримтын хамт холбогдох нотлох баримтыг хавсарган бэлэн бусаар гүйлгээ хийгдэх ба бэлнээр гүйлгээ хийхийг хориглоно.
- г) Хэлтсийн Хяналт, шалгалт, дотоод аудитын тасаг, аймгийн Санхүүгийн хяналт Аудитын алба, аймгийн Төрийн аудитын газар, Нийгмийн даатгалын Ерөнхий газар зэрэг байгууллага нь хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ.

8.4. Санхүүгийн бус хяналт

Хэлтсийн санхүүгийн бус хяналтыг НДЕГазраас батлагдсан чиглэлийн дагуу Хяналт, шалгалт, дотоод аудитын тасаг төлөвлөгөө боловсруулан жилийн турш анхан шатны хяналтыг хэрэгжүүлнэ.

Дараагийн шатны хяналтыг аймгийн ЗДТГазрын харьяа Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтэс, НДЕГазар хэрэгжүүлнэ.



8.5 Хяналтад хамрагдсан байгууллага болон сонирхогч этгээдээс хэрэгжүүлэх авлигын эсрэг хяналт

8.5.1 Хэлтэс нь авлигатай тэмцэх үйл ажиллагааны менежментийн тогтолцоог хэрэгжүүлэгч байх бөгөөд өөрийн гаргасан “Авлигын эсрэг үйл ажиллагааны журам”, “Авлигын эрсдлийн үнэлгээний журам”, “Шүгэл үлээх журам” зэрэгт зааснаар авлигын эсрэг хяналтыг хэрэгжүүлэн ажиллана.

8.5.2 Хэлтэс нь авлигатай тэмцэх үйл ажиллагааны менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх явцад сонирхогч талаас байгууллагад авлигын эрсдэл учруулж болох бөгөөд үүнээс урьдчилан сэргийлэхийн тулд дараах арга хэмжээг авсан эсэхэд “Авлигын эсрэг үйл ажиллагааны журам”, “Авлигын эрсдлийн үнэлгээний журам”, “Шүгэл үлээх журам” хяналт тавина:

8.6 Авлигатай тэмцэх амлалт мэдэгдэл

“Авлигын эрсдлийн үнэлгээний журам”-ын дагуу авлигын эрсдэл багатай сонирхогч талуудын үйл ажиллагаанд авлигатай тэмцэх үүрэг хүлээхгүй байж болно.

“Авлигын эрсдлийн үнэлгээний журам”-ын дагуу авлигын эрсдэл дунд болон өндөр сонирхогч талуудын үйл ажиллагаанд авлигын эсрэг менежментийн тогтолцоог хэрэгжүүлж, авлигаас урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэрэгсэл ашиглана.

8.7 Бэлэг сэлт, найр тавин тал татах хандлага, хандив тусламж, түүнтэй ижилсгэх бусад зүйл

8.7.1 Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь аливаа бэлэг сэлт, найр тавих хандлага, хандив тусламж, хүсэлт, түүнтэй ижилсгэх бусад зүйл болон төсөөтэй ашгийн төлөөх зүйлээс татгалзаж, өгөх болон авахаас урьчилан сэргийлж ажиллана.

8.7.2 Ашгийн төлөөх хэмээн заасан зүйлд дор дурдсаныг ойлгоно. Үүнд:

- а) Бэлэг сэлт, зугаа цэнгэл, найр тавин тал засах
- б) Улс төрийн болон буяны зорилготой хандив, тусламж өгөх
- в) Идэвхжүүлэх зарлага гаргах
- г) Ивээн тэтгэх
- д) Нийгмийн тустай ажил
- е) Сургалт зохион байгуулах
- ё) Клубийн гишүүн болгох
- ж) Хувийн тусламж, дэмжлэг үзүүлэх
- з) Нууц болон давуу эрхийн мэдээлэл өгөх зэрэг болно

8.8 Авлигатай тэмцэх хяналтын үл зохицлыг хянах

Авлигын эсрэг хяналтаар авлигын эрсдэлийг хянан, удирдаж чадахгүй байгаа, эсхүл хүсэл эрмэлзлэлгүй үед зохих алхамыг хийхгүй байгаа үед, ДХШБаг мэргэжлийн судалгаа хийж холбогдох авлигын эрсдэлийг байгууллагаас удирдах боломж бүрдүүлэх зорилгоор сонирхогч талуудтай хийсэн онцгой мөнгөн гүйлгээ, төсөл хөтөлбөр, ажил үйл, харилцаа холбоонд мэргэжлийн судалгааг хийж, дүгнэлтийг гарган ажиллана.

- а) “Шүгэл үлээх журам”-ын дагуу үл зохицол гарсан тохиолдолд ЧУХ авлигын эрсдэлийн мөн чанарыг тодорхойлж, дүгнэлтэнд үндэслэн тухайн үйл ажиллагааг цуцлах, түдгэлзүүлэх, зогсоох буюу татгалзах арга хэмжээг авна.
- б) Ирээдүйд гарч болох эрсдэлийг тооцож ажиллах, эрсдэл гарсан тохиолдолд цаг хугацаа алдалгүй таслан зогсоох.



8.9 Гомдол мэдүүлэх

Нийгмийн даатгалын хэлтэс нь авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг “Шүгэл үлээх журам”-ын дагуу шийдвэрлэх ба хэлтсийн бүх ажилтнууд мэдээлэх журмыг ойлгож, мэдэх, түүнийг хэрэглэх, тэдний эрх үүрэг журмын хүрээнд хамгаалагдсан байна.

8.10 Авлигын зөрчлийг илрүүлэх, зохицуулах

Авлигатай тэмцэх бодлого, менежментийн тогтолцоо зөрчигдсэн тохиолдолд дараах арга хэмжээг авна.

- а) авлига, авлигын эсрэг бодлого журам зөрчигдсэн тухай мэдээлэл, ирсэн, илэрсэн, үндэслэлтэйгээр сэжиглэгдсэн бүх тохиолдлыг ДХШБ үнэлж, судалгаа хийнэ.
- б) авлигын эсрэг хууль зөрчсөн нь судалгаагаар тогтоогдсон тохиолдолд ЧУХ хуульд заасан зохих арга хэмжээ авч ажиллана.
- в) ЭБАТ нь авлигын шинжтэй үйлдлийг судлах, хянан шалгах, холбогдогчоос баримт мэдээлэл авах эрхтэй.
- г) судалгаагаар илэрсэн зөрчил, мэдээллийг судалж дуусмагц Авлигатай тэмцэх газрын эрх бүхий албан тушаалтанд шилжүүлнэ.
- д) судлан тогтоосон баримт, ажлын дүгнэлтийн нууцыг судлан илрүүлэгч хариуцна.

ЕС. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

9.1 Хяналт, шинжилгээ, хэмжилт, задлан шинжилгээ үнэлгээ

Авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцооны дагуу дараах хэсэгт хяналт шинжилгээ явуулна. Үүнд:

- а) сургалтын үр нөлөө, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус үйл ажиллагааны үр дүн, “Шүгэл үлээх журам”-ын дагуу хүлээн авсан өргөдөл гомдлын тоон үзүүлэлт зэрэгт хяналт шинжилгээ, хэмжилт хийнэ
- б) хяналт шинжилгээний хариуцлагыг АЭМТХАХ хариуцна.
- в) хяналт шинжилгээ, хэмжилтийг ЧГА хэрэгжүүлсэн байдал, авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, баримтжуулсан мэдээлэл, “Шүгэл үлээх журам”-ын дагуу хүлээн авсан өргөдөл, гомдол зэрэгт үндэслэн дүгнэнэ
- г) хяналт шинжилгээ хэмжилийг жилд 1 удаа тухайн онд багтаан гүйцэтгэнэ
- д) хяналт шинжилгээ хэмжилтийн үр дүнг дараа оны эхний сард багтаан тооцож, дараагийн төлөвлөгөөг боловсруулна.
- е) хяналт шинжилгээ хэмжилтийн үр дүнг ЧУХ-д дараа оны эхний сард багтаан тайлагнана.

Шаардлагатай тохиолдолд баримтжуулсан мэдээллийн арга, үр дүнг ашиглаж болно.

9.2 Дотоод аудит

9.2.1 Авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцоо хэрэгжиж байгаа байдал болон үйл ажиллагаанд үр ашигтай байгаа эсэхийг тодруулах, авлигыг илрүүлэх, таних, урьдчилан сэргийлэхэд туслах зорилгоор ЭБАТ, ДХШБ төлөвлөсөн хуваарийн дагуу



хяналт шалгалт хийх бөгөөд авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцооны талаар мэдээллийг цуглуулж, дотоод аудитын хөтөлбөрийг бүхэлд нь юм уу тодорхой хэсгийг хэрэгжүүлэхэд гурав дахь этгээдийг ашиглаж болно.

9.2.2 Байгууллага доор дурдсан зүйлийг мөрдөнө. Үүнд

а) аудитын хөтөлбөрийг төлөвлөн гарган батлах, хэрэгжүүлэх, тогтмол хийх
б) аудит тус бүрийн хамрах хүрээ, шалгуур үзүүлэлтийг тодорхойлох
в) аудитын үйл явцын бодит хандлага, шударга байдлыг хангахын тулд тохирох ур чадвартай аудиторыг сонгох

г) аудитын үр дүнг холбогдох удирдлага, авлигатай тэмцэх эрх бүхий албан тушаалтан, дээд шатны удирдлага, хяналтын бүлэгт заавал мэдээлж танилцуулах

д) аудитын үр дүн, хэрэгжүүлэх хөтөлбөрийн нотолгоо болгон баримтжуулсан мэдээлэл хэлбэрээр хадгалах

9.2.3 Аудит нь эрсдэл, шаардлага дээр тулгуурласан зохимжтой байх ба хяналт, тогтолцоо, эсвэл, дотоод аудитын явцад доор дурдсан доголдол гарсан тохиолдолд хэрэгжүүлнэ. Үүнд:

а) авлига, эсвэл авлига сэжиглэгдсэн үед
б) авлигатай тэмцэх бодлого, авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцооны шаардлага үл биелүүлсэн тохиолдолд

в) байгууллагын мөрдвөл зохих авлигатай тэмцэх шаардлагын дагуу бизнесийн холбоотноос тохирлыг хангаагүй

г) авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцооны сул тал болон сайжруулах боломж нөхцөл зэрэг болно.

9.2.4 Аудитын хөтөлбөрийн дагуу Нийгмийн даатгалын хэлтсийн баталгааг хангах ба аудитын дүнг хүлээн зөвшөөрч үүрэг хүлээнэ. Үүнд:

а) үйл явцын дагуу ажилтан албан хаагч, боловсон хүчин урьдчилан тодорхойлсон үүрэг хүлээнэ.

б) авлигатай тэмцэх эрх бүхий албан тушаалтан (аудитын хамрах хүрээнд оруулаагүй бол авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцоо, эсвэл, бусад төстэй ажлын хариуцлагыг хүлээнэ)

в) аудитаар шалгуулж байгаа хэлтэс, нэгжээс өөр хэсгээс тохирох хүн аудит хийнэ

9.3 Удирдлагын дүн шинжилгээ

9.3.1 Удирдлагын дүн шинжилгээ

ЧУХ нь авлигатай тэмцэх менежментийн тогтолцоог төлөвлөсөн хуваарийн дагуу тогтвортой, нийцтэй, нөлөө бүхий байгаа эсэхийг хянахдаа үл тохирлууд, залруулах арга хэмжээ, хяналт, шинжилгээ, хэмжилтийн үр дүн, аудитын дүн, авлигын мэдээ тайлан, судлан илрүүлэх ажил, байгууллагад тулгарч буй авлигын эрсдэлийн цар хэмжээ, шинж чанар, авлигын эрсдэлд чиглэсэн үйл ажиллагааны үр нөлөө зэргийг дүн шинжилгээнд тусгана.

ЧУХ-ны дүн шинжилгээ нь авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцоонд байнгын сайжруулалт хийх нөхцөл боломж, тогтолцоонд өөрчлөлт оруулах хэрэгцээний талаарх шийдвэр болно.

ЧУХ-ны дүн шинжилгээг нэгтгэж ДХШБагт мэдүүлэх ба дүн шинжилгээг баримтжуулсан мэдээлэл хэлбэрээр хадгална.



9.3.2 Хяналтын бүлгийн дүн шинжилгээ

ДХШБаг нь ЧУХ-ноос өгсөн дүн шинжилгээнд үндэслэн авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцоонд үнэлэлт дүгнэлт өгнө.

ДХШБагийн хийсэн дүн шинжилгээний үр дүнг баримтжуулсан мэдээлэл хэлбэрээр хадгална.

9.4 Авлигатай тэмцэх эрх бүхий албан тушаалтны дүн шинжилгээ

Авлигатай тэмцэх эрх бүхий албан тушаалтан нь авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцоог хэрэгжүүлж, даган мөрдөж байгаа эсэхийг тогтмол хугацаанд үнэлж дүгнэнэ.

- а) байгууллагад тулгарч буй авлигын эрсдэлийг үр нөлөөтэйгээр хянан зохицуулж авлигын эсрэг менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх ажлын хэсэгт чиглэл өгч ажиллана.
- б) үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд тайлагнах хугацааны давтамжийг байгууллагын шаардлагад тусган тодорхойлох ба ингэхдээ нэг жилд нэг буюу хэд хэдэн удаа хийнэ.

Авлигатай тэмцэх эрх бүхий албан тушаалтан эсвэл түр ажлын хэсгээс авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцооны зохистой байдал, хэрэгжилт, судлан илрүүлэх ажил ба аудитын үр дүнгийн тайланг гаргаж, хяналтын бүлэг дээд шатны удирдлага, эсвэл хяналтын бүлгийн хороо, дээд шатны удирдах хороонд мэдээлэн танилцуулна.

АРАВ. САЙЖРУУЛАЛТ

10.1. Үл тохирол ба залруулах арга хэмжээ

Тасаг, нэгжүүд процессуудын хэрэгжилтийн явцад болон гүйцэтгэлд гарсан үл тохирлыг илрүүлэх, тэдгээрийг аль болох илэрсэн даруйд засч, залруулах, процессийн шаардлагууд болон шалгууруудыг хангагдаагүйн улмаас үүсэх “Үл тохиролд хяналт” тавьж ажиллана.

Нийгмийн даатгалын байгууллага нь үл тохирлоо илэрсэн болон болзошгүй үл тохирол гэж ангилан авч үзээд залруулах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллаж байна.

Үл тохирол илрэхэд дараах арга хэмжээг авна. Үүнд:

- а) Үл тохиролд шуурхай хариу үйлдэл үзүүлэх
 - Хяналтандаа авч залруулах шаардлагатай арга хэмжээг авах
 - Үр дагаврыг арилгах
- б) Үл тохиролыг дахин гаргахгүйн тулд учир шалтгааныг нь судлан арилгах арга хэмжээ авах;
 - Үл тохиролыг үнэлж, дүгнэх
 - Үл тохирлын учир шалтгааныг тодруулах
 - Ижил төрлийн өөр үл тохирол гарсан эсэх, гарах магадлалтай эсэхийг тодорхойлох
- в) Шаардлагатай арга хэмжээг авах
- г) Залруулахаар авсан арга хэмжээний үр нөлөөг тодорхойлон дүгнэх
- д) Шаардлагатай тохиолдолд авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцоог өөрчлөх зэрэг болно.



Тухайн үл тохиролын үүсгэсэн үр дагаврыг арилгахуйц төвшинд залруулах арга хэмжээ авна.

- Байгууллага нотолгоо болгон дараах баримтжуулсан мэдээллийг хадгална, үл тохиролын шинж чанар, түүний мөрөөр авсан арга хэмжээ
- Авсан залруулах арга хэмжээний үр дүн

10.2 Байнгын сайжруулалт

Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь авилгатай тэмцэх ажлын менежментийн тогтолцооны тохиромжтой, таарамжтай, нөлөө бүхий байдлыг байнга сайжруулна.

Хэлтэс нь байнгын сайжруулалтын хэсэг гэж авч үзэх хэрэгцээ болон боломжуудыг тодорхойлохдоо

- Эрсдэлийн үнэлгээний үр дүн
- Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүн
- Хяналт шалгалт дотоод аудитын тасгийн ажлын үр дүн
- Аудитын байгууллагын дүгнэлт болон зөвлөмж
- Бүтэц зохион байгуулалт, шууд болон шууд бус үйлчилгээнээс илэрсэн үл тохирол бүрийг хэлтсийн дэргэдэх даргын зөвлөлийн хурлаар сар бүр хэлэлцэн тухай бүр нь сайжруулна.

Авилгатай тэмцэх ажлын менежментийн тогтолцооны гүйцэтгэл болон үр нөлөө, хэрэглэгчийн шаардлагыг хангах, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд шаардлагатай дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хоёр жил тутам ажлын байрны зураг авалт, дүн шинжилгээ хийн гүйцэтгэж үл тохирол үүсэж буй процессыг олж илрүүлэн засаж сайжруулна
- Тааламжгүй үр дүнг залруулах, сэргийлэх буюу бууруулахдаа СҮАЖ-ОАНДХ-05-2017 журам болон “Шүгэл үлээх журам-2022” баримтална
- Хэлтсийн дотоод журам болон Байгууллагын бодлого, стратегийн зорилтод тусган сайжруулна
- Нийтээр дагаж мөрдөж, хэрэгжилтийг ханган, үр нөлөөг тооцно

ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС